



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Хулд сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/03/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга,гэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
БХС	Байгаль хамгаалах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 85

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.БЯМБАЛХАГВА ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Хулд сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Эрүүл мэндийн төвд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгч санхүүгийн тайланг баталгаажуулаагүй, мөн Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл өндөр, өмнөх оны төлбөрийн акт бүрэн төлөгдөөгүй зэрэг зөрчил илэрсэн нь материаллаг дүнтэй бөгөөд санхүүгийн тайланд бүрэн тархаагүй.

Эдгээр нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 2.2 дахин их, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


0012020995

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		748,747.9	1,097,171.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	211,450.5	263,934.8
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	237,819.5	400,385.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	286,477.9	419,851.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	13,000.0	13,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,942,487.3	3,911,146.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,942,487.3	3,911,146.4
39200	Биет хөрөнгө		3,886,105.4	3,856,256.5
39300	Биет бус хөрөнгө	13	56,381.9	54,889.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,691,235.2	5,008,318.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		41,662.6	76,100.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	41,662.6	76,100.0
41300	Өглөг	17а, 17б	41,662.6	76,100.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,649,572.5	4,932,218.2
51	Засгийн газрын хувь оролцоо		4,649,572.5	4,932,218.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,406,357.5	1,406,357.5
51200	Хуримтлагдсан үр дүн		1,423,015.0	1,705,660.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,820,200.0	1,820,200.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,691,235.2	5,008,318.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,960,460.0	3,002,306.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		37,041.6	67,323.6
110	Орлогын албан татвар		30,733.7	21,578.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		30,733.7	21,578.9
113	Хөрөнгийн албан татвар		1,466.0	39,238.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,841.9	6,506.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	379,632.0	491,584.1
120	Нийтлэг татварын бус орлого		377,302.0	488,204.7
121	Хөрөнгийн орлого		2,330.0	3,379.4
13	ТҮСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,543,786.4	2,443,398.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,722,633.8	2,697,900.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,722,633.8	2,697,900.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,067,216.7	2,601,700.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,300,171.9	1,286,275.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		160,577.6	166,687.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		86,832.2	208,141.9
2104	Хангамж, бараа материалын зардал		89,451.7	100,204.8
2105	Нормативт зардал		42,162.8	205,647.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		21,714.0	47,803.8
2107	Томилолт, зочны зардал		8,920.4	5,858.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		46,858.6	9,708.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		310,527.6	571,374.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		655,417.1	96,199.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		237,826.1	304,405.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		86,709.9	21,760.0

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	151,116.3	282,645.7
----	--	-----------	-----------

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,498,456.3	4,498,456.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,498,456.3	4,498,456.3
9	Тайлант үеийн үр дүн	151,116.3	151,116.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,649,572.5	4,649,572.5
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,649,572.5	4,649,572.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,649,572.5	4,649,572.5
19	Тайлант үеийн үр дүн	282,645.7	282,645.7
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,932,218.2	4,932,218.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,734,116.5	2,438,800.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	37,041.6	67,323.6
110	Орлогын албан татвар	30,733.7	21,578.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	30,733.7	21,578.9
113	Хөрөнгийн албан татвар	1,466.0	39,238.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,841.9	6,506.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,388.5	5,675.5
1181	Газрын төлбөр	453.4	831.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,288.5	165,011.1
120	Нийтлэг татварын бус орлого	150,958.5	161,631.6
121	Хөрөнгийн орлого	2,330.0	3,379.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,543,786.4	2,206,465.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,446,930.5	2,199,879.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,446,930.5	2,199,879.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,792,407.0	2,103,235.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,300,218.9	1,286,974.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,577.6	166,680.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,226.6	206,837.4
2104	Хангамж, бараа материалын зардал	80,343.4	95,427.7
2105	Нормативт зардал	37,201.5	143,336.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,187.4	72,423.4
2107	Томилолт, зочны зардал	8,920.4	5,858.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,858.6	8,761.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,872.5	116,936.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	654,523.6	96,643.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	287,186.0	238,921.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	116,989.8	186,436.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	116,989.8	186,436.7
2200	Дотоод эх үүсвэрээр	116,989.8	186,436.7
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-116,989.8	-186,436.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-59,500.0	0.0

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	59,500.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	110,696.2	52,484.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,754.3	211,450.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	211,450.5	263,934.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,386,206.1	2,144,657.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,042,107.5	1,968,687.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,964,652.4	1,912,636.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,267,745.3	1,254,011.3
210101	Үндсэн цалин	882,482.5	887,885.7
210102	Нэмэгдэл	296,652.9	278,701.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,396.0	3,525.0
210104	Урамшуулал	82,413.9	82,099.6
210105	Гэрээт ажлын хөлс	1,800.0	1,800.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,795.6	162,523.5
210201	Тэтгэврийн даатгал	115,841.0	112,676.9
210202	Тэтгэмжийн даатгал	12,993.0	12,788.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,253.5	10,032.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,403.2	2,380.8
210205	Эрүүл мэндийн даатгал	25,304.9	24,645.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,143.9	203,244.0
210301	Гэрэл, цахилгаан	18,801.2	17,853.6
210302	Түлш, халаалт	189,866.8	184,914.5
210303	Цэвэр, бохир ус	475.9	475.9
2104	Хангамж, бараа материалын зардал	75,779.4	75,685.1
210401	Бичиг хэрэг	6,152.1	6,145.7
210402	Тээвэр, шатахуун	41,481.3	41,456.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,997.1	3,979.2
210404	Ном, хэвлэл	827.1	827.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,229.6	7,203.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,092.2	16,073.6
2105	Нормативт зардал	48,486.2	44,866.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,522.2	22,026.4
210502	Хоол, хүнс	19,778.3	19,774.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,185.7	3,066.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,369.2	69,331.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,244.8	22,244.8
210604	Урсгал засвар	47,124.4	47,086.2
2107	Томилолт, зочны зардал	5,911.1	5,788.0
210702	Дотоод албан томилолт	5,911.1	5,788.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,619.6	5,791.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650.0	1,642.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,077.0	787.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	874.1	661.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	183.0	66.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,845.4	1,655.7
210807	Газрын төлбөр	240.1	229.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	750.0	750.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,802.1	91,395.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,447.1	82,063.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,355.0	9,331.8

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,455.1	56,050.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,455.1	56,050.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,322.7	20,645.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,770.0	33,165.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,362.4	2,240.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	245,598.6	175,969.9
2200	Дотоод эх үүсвэрээр	245,598.6	175,969.9
223001	Бусад хөрөнгө	245,598.6	175,969.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,500.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	98,500.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,386,206.1	2,133,149.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,192,805.0	1,189,139.8
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,192,805.0	1,189,139.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	877,120.1	843,960.4
122005	Орон нутгийн төсвөөс	756,429.4	723,269.7
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	120,690.7	120,690.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,601.0	14,717.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,601.0	14,717.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	288,680.0	85,331.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,647.5	62,959.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,665.2	22,372.2
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	190,367.3	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		189,701.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	178,194.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
610001	Төсвийн байгууллага	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	107	107
620001	Удирдах ажилтан	12	12
620002	Гүйцэтгэх ажилтан	62	62
620003	Үйлчлэх ажилтан	31	31
620004	Гэрээт ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		247,221.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		247,221.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		220,121.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		32,963.2
210104	Урамшуулал		32,963.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,156.5
210201	Тэтгэврийн даатгал		2,801.3
210202	Тэтгэмжийн даатгал		329.6
210203	ҮОМШӨ-ний даатгал		109.5
210204	Ажилгүйдлийн даатгал		256.9
210205	Эрүүл мэндийн даатгал		659.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,593.4
210301	Гэрэл, цахилгаан		1,216.0
210302	Түлш, халаалт		575.0
210303	Цэвэр, бохир ус		1,802.4
2104	Хангамж, бараа материалын зардал		19,794.9

210401	Бичиг хэрэг		1,559.0
210402	Тээвэр, шатахуун		10,833.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		250.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,152.3
2105	Нормативт зардал		98,469.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		66,442.2
210502	Хоол, хүнс		10,940.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		21,086.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,426.9
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,249.9
210602	Тавилга		5,000.0
210604	Урсгал засвар		5,177.0
2107	Томилолт, зочны зардал		70.0
210702	Дотоод албан томилолт		70.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,970.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,970.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		36,849.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		31,838.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		5,010.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		27,100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		27,100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		26,600.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		500.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		9,828.3
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		9,828.3
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		247,251.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		247,251.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		16,122.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,362.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,829.2
131106	ЭМДаатгалын нэмэлт орлого		139,937.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		29.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		29.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Хулд сум нь эрхэм зорилгоо “Төр иргэний оролцоог ил тод нээлттэй болгож иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас сумын төсвийн 4 байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тайлангийн нийт хөрөнгийн дүн 5,008,318.2 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 25,041.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 15,024.9 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 317,083.0 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	748,747.9	1,097,171.8	348,423.9
Мөнгөн хөрөнгө	211,450.5	263,934.8	52,484.3
Авлага	237,819.5	400,385.8	162,566.3
Бараа материал	286,477.9	419,851.3	133,373.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,942,487.3	3,911,146.4	(31,340.9)
Үндсэн хөрөнгө	3,942,487.3	3,911,146.4	(31,340.9)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,691,235.2	5,008,318.2	317,083.0
Нийт өр төлбөр	41,662.6	76,100.0	34,437.4
Богино хугацаат өр төлбөр	41,662.6	76,100.0	34,437.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,649,572.5	4,932,218.2	282,645.7
Засгийн газрын хувь оролцоо	4,649,572.5	4,932,218.2	282,645.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,691,235.2	5,008,318.2	317,083.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 52,484.3 мянган төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт нэмэгдсэн, малын тоо толгойн албан татварын орлого сайн төвлөрсөнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 162,566.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 236,933.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгон, Эрүүл мэндийн газар авлага үүсгэн бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын үлдэгдэл 419,851.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 133,373.4 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн газрын цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах эм, боох, хамгаалах хэрэгслийн үлдэгдэл өмнөх оноос 63,820.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 10,466.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авч, хандиваар 127,954.5 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 29,591.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 9,238.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 5,419.0 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасан, хуримтлагдсан элэгдэл 1,209,406.6 мянган төгрөг болж өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,932,218.2 мянган төгрөг болж 282,645.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.2 Орлого бүрдүүлэлт

Хулд сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 06/02 дугаар тогтоолоор Хулд сум тайлант онд 94,700.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 147,002.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 155.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Үйл ажиллагааны орлого	25,00.0	21,578.9	3,421.1	86.3
Бууны албан татвар	1,700.0	1,590.0	110.0	93.5
Малын тоо толгойн албан татвар	10,000.0	37,648.0	-27,648.0	376.5
Улсын тэмдэгтийн хураамж	3,200.0	2,195.1	1,004.9	68.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	75.4	924.6	7.5
Газрын төлбөр	900.0	831.1	68.9	92.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,500.0	3,405.0	95.0	97.3
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.0	3,379.4	-3,379.4	
Дүн	45,300.0	70,702.9	25,402.9	156.1
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	32,400.0	43,121.2	-10,721.2	133.1
Торгуулийн орлого	16,000.0	32,183.5	-16,183.5	201.1
Бусад орлого	1,000.0	995.0	5.0	99.5
Дүн	49,400.0	76,299.7	26,899.7	154.4
Нийт дүн	94,700.0	147,002.6	52,302.6	155.2

Эх сурвалж: Хулд сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө өндөр ирсэн учир 3,421.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Хулд суманд нийт бүртгэлтэй татвар төлдөг 53 буу байдаг жилийн татвар 30.0 мянган төгрөг байхад хий өндөр төлөвлөснөөс бууны албан татвар 110.0 мянган төгрөгөөр тасарсан.

Сумын нийт малын тоо толгойтой уялдуулан малын тоо толгойн албан татвараа төлөвлөөгүйгээс төлөвлөгөө 27,648.0 мянган төгрөгөөр давсан байна.

Улсын тэмдэгтийн хураамж 1,004.9 мянган төгрөгөөр тасарсан нь архи тамхины тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын хугацаа дуусаагүй учир хураамж орж ирээгүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 924.6 мянган төгрөгөөр тасарсан нь ковидын нөхцөл байдалд шинээр байшин барилга баригдаагүйтэй холбоотой.

Сумын айл өрх бүрд газрын төлбөрийн нэхэмжлэх хүргүүлсэн боловч 68.9 мянган төгрөгөөр тасарсан нь сумын татварын байцаагч муу ажилласнаас болсон байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж 95.0 мянган төгрөгөөр тасарсан нь 1 аж ахуй нэгж хураамжаа төлөөгүйгээс болж тасарсан байна.

Торгуулийн орлого 16,183.5 мянган төгрөгөөр давсан нь торгуулийн орлого тухайн сумын орлогод ордог болсонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хулд сумын ИТХ-ын 2020 оны 02/02 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,253,154.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,253,154.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Хулд сумын ИТХ-ын 2021 оны 06/02 болон 07/01 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 133,051.3 мянган төгрөгөөр өсгөн, 2,386,206.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд гарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилтийг хасан баталсан байсныг жилийн эцэст өсгөн баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,386,206.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,964,652.4 мянган төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардалд, 77,455.1 мянган төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд, 245,598.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 98,500.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,313,495.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 756,429.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27,601.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 98,312.2 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 190,367.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,309,830.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 723,269.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,717.4 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 85,331.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 190,367.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 62,959.7 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 17,687.8 мянган төгрөгөөр тасарсан, туслах үйл ажиллагааны орлого 22,372.2 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4,707.0 мянган төгрөгөөр давсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлого бөгөөд тайлант онд шинээр нэмж зээл гаргаагүйгээс төлөвлөгөө тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлогод мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлогыг бүртгэдэг байна. Байгаль цаг уурын нөхцөлийн улмаас өвс тэжээлийн борлуулалт түрүү онуудтай харьцуулахад өндөр байснаас тус орлого давж орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,144,657.1 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 1,912,636.7 мянга, хөрөнгийн зардал 175,970.0 мянган төгрөг, урсгал зардлаас 56,050.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 13,493.5 мянган төгрөгийг орон нутгийн болон улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 16,122.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 75,362.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,829.2 мянган төгрөг, ЭМД-ын сангийн нэмэлт орлого 139,937.0 мянган төгрөг нийт 247,251.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшлын зардалд 32,963.2 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 4,156.5 мянга, байр ашиглалттай холбоотой зардалд 3,593.4 мянга, хангамж бараа материалын зардалд 19,794.9 мянга, нормативт зардалд 98,469.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 11,426.8 мянга, томилолтын зардалд 70.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2,970.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 36,849.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 27,100.0 нийт 237,393.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 9,828.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 29.4 мянган төгрөг. Үлдэгдэл 29.4 мянган төгрөг нь Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ковидын нөхцөл байдал болон хаврын шороон шуурганы аюултай үзэгдэлд хүнд гарз хохирол амссан сумын иргэдэд тухайн нутагт зам ашигласан 1 компани 10,000.0 мянган төгрөг, нутгийн иргэд 5,122.4 мянган төгрөгийн хандивыг өгсөн байна. Тухайн хандивын мөнгийг сумын элсэн шороог түрсэн машины шатахуун ажлын хөлсөнд зарцуулж, үлдэгдэл 9,828.3 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар болсон.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн төв нь байгууллагын орон тоо, цалингийн санд батлагдаагүй 2 орон тоонд эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээдийг авч ажиллуулсан. Мөн ковидын төлбөртэй шинжилгээний орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүй, өөрийн хувийн дансаар авч ашиглан, санхүүгийн тайланд тусгаагүй. Анхан шатны баримтгүй шатахууны зардал гаргасан зэрэг ашиглангийн шинжтэй зүйл илэрсэн.

Байгууллагын удирдлага иргэдээс эм, тарианы төлбөр хувийн дансаар авсан. Аудит эхлэх үед аймгийн Эрүүл мэндийн газартай тооцоо нийлэхэд 1,664.0 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг хүлээн авсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байсан. Иймд бараа материалын тайлан нь үнэн зөв гарсан гэх хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй, энэ нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархсан тул байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 26 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж үзлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол зөрчсөн зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ОНХС-ийн худалдан авалт, БХС-ын зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт сумын Засаг даргын Тамгын газар нь нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 47,482.1 мянган төгрөгийн 5 хугацаатай төлбөрийн акт, 78,209.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагын хэрэгжилт 100 хувь, төлбөрийн актын хэрэгжилт 14 хувь буюу Сум хөгжүүлэх сангийн төлбөрийн актын үлдэгдэл 40,812.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй хэрэгжилт 67.5 хувьтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	5	47,482.1	4	6,670.0	1	40,812.1	14
Албан шаардлага	10	78,209.0	10	78,209.0			100
Зөвлөмж							
Нийт	15	125,691.1	15	84,879.0	1	40,812.1	67.5

Өмнөх оны Сум хөгжүүлэх сангийн төлбөрийн акт нь хугацаа хэтрэлттэй зээл болон зориулалт бус зээлд төлбөрийн акт тавьсан байна. Үүнээс зарим нэг хугацаа хэтрэлттэй зээл нь цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулж чадаагүйгээс зээлээ төлж чадаагүй, мөн зориулалт бус зээлийн үлдэгдэл төлөгдөөгүй үлдсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газар, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 38,034.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,180.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 18,194.2 мянган төгрөгийн 5 алдааг буцаан төлүүлэх төлбөрийн акт, 18,660.5 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 96.9 хувийг залруулагдаагүй, 3.1 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 14,226.0 мянга буюу 37.4 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 12,097.2 мянга буюу 31.8 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 11,711.6 мянга буюу 30.8 хувь нь дотоод хяналт хариуцлагатай холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн нь дотоод хяналтыг сайжруулан, удирдлагуудын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллуулах шаардлагатай байгааг харуулж байна.

4.1 Залруулсан алдаа

Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сан, сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангийн үр дүнгийн тайланд 12,610.0 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан;
2. Байгаль хамгаалах сангийн үр дүнгийн тайланд 14,610.0 мянган төгрөгийг тайлагнаагүй;
3. Байгаль хамгаалах сангийн уул уурхайн 2,000.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг шууд орлогоор тайлагнасан;
4. Мал хамгаалах сангийн 3,200.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн өвсийг өглөгөөр бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 34,420.0 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгаль хамгаалах сангаас 2021 оны байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулалгүй 14,610.0 мянган төгрөгийг зарцуулсан;
2. Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь хувь хүн авах 7,815.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар 22,425.5 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 07/01 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 58,900.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 69,369.2 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Дундговь аймгийн Хулд сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 26 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЗДТГ	1	2,100.0					1	2,100.0		
2	ЕБС	1	0.0					1			
3	ИТХ	1	0.0					1			
4	ОНХС	1	9,997.2					1	9,997.2		
5	БХС	1	14,610.0					1	14,610.0		
6	ОННТ	2	58,900.2							2	58,900.2
	дүн	7	85,607.3	-	-	-	-	5	26,707.1	2	58,900.2
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЗДТГ	2	3,312.0	1	1,180.00			1	2,132.0		
2	ИТХ	1	944.2					1	944.2		
3	ЭМТ	2	3,968.2			2	3,968.2				
4	ЕБС	1	0.0					1			
5	ЦЭЦЭРЛЭГ	1	3,487.2					1	3,487.2		
6	СХС	1	14,226.0			3	14,226.0				
8	БХС	3	29,219.9	3	29,219.9						
9	МХС	2	11,015.5	1	3,200.0			1	7,815.5		
	дүн	13	66,173.0	5	33,599.9	5	18,194.2	5	14,378.9	-	-
	Нийт зөрчлийн дүн	20	151,780.3	5	33,599.9	5	18,194.2	10	41,086.0	2	58,900.2